МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022 ОНЫ II УЛИРАЛ

Улаанбаатар хот

Тойм бэлтгэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт,
Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгааны сектор

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Нарны зам, 55-р байр 2 давхарт 3 тоот
Утас: (+976) 77121286
Вэб хуудас: www.institute.gov.mn

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ 04

ЗУРГИЙН ЖАГСААЛТ 04

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД 07

- Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд 07
- Нийгмийн даатгалын үзүүлэлтүүд 15
- Сарын дундаж цалингийн үзүүлэлтүүд 19

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 23

- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ 23
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд 27

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО 32

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, мянган хүн 8
Хүснэгт 2. Ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн 12
Хүснэгт 3. Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч байгууллага, даатгуулагч, улирлаар 15
Хүснэгт 4. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэдийн тоо, төрөл, улирлаар 16
Хүснэгт 5. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр 18
Хүснэгт 6. Ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, мянган төгрөг 19
Хүснэгт 7. Ажиллагчдын сарын дундаж цалин, ажиллагчдын тооны бүлэг, хүйсээр, мянган төгрөг 20
Хүснэгт 8. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар 23
Хүснэгт 9. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэн, улирлаар 24
Хүснэгт 10. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд, 2022 оны II улирал 25

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Ажиллах хүч, ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо, мянган хүн, 2022 оны II улирал 7
Зураг 2. Ажиллагчид, ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн 8
Зураг 3. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүн, 2022 оны II улирал 9
Зураг 4. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбар, өмнөх оны мөн үеэс, мянган хүн, 2022 оны II улирал 10
Зураг 5. Ажиллагчдын тооны өөрчлөлт, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн 3 салбараар, хүйсээр, өмнөх оны мөн үеэс, мянган хүн, 2022 оны II улирал 10
Зураг 6. Ажиллагчдын тоо, хот, хөдөө, бүсээр, 2022 оны II улирал 11
Зураг 7. Ажилгүй хүний тоо, өөрчлөлт, өмнөх оны мөн үеэс, мянган хүн 12
Зураг 8. Ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, хувиар 12
Зураг 9. Ажиллагчдын тоо, ажилгүйдлийн түвшин, улирлаар 13
Зураг 10. Ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 13
Зураг 11. Даатгуулагчийн тоо, төрөл, улирлаар 15
Зураг 12. Сайн дураар даатгуулсан хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдын тоо, улирлаар 16
Зураг 13. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэд, төрлөөр, хувиар 17
Зураг 14. Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авсан иргэдийн тоо, төрлөөр 17
Зураг 15. ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэд, төрлөөр, хувиар 18
Зураг 16. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан хүн, зарцуулсан хөрөнгө, улирлаар 19
Зураг 17. Дундаж болон медиан цалин, мянган төгрөг, улирлаар 20
Зураг 18. Ажиллагчдын сарын дундаж цалин, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, улирлаар 21

Зураг 19. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар....23
Зураг 20. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролын түвшин, дүнд эзлэх хувиар, 2022 оны II улирал....24
Зураг 21. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, хамгийн их 5 улсаар, дүнд эзлэх хувиар, 2022 оны II улирал....26
Зураг 22. Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэд, 2022 оны II улирал....27
Зураг 23. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, сая төгрөг, 2022 оны VI сарын байдлаар....27
Зураг 24. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2022 оны VI сарын байдлаар....28
Зураг 25. Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2022 оны VI сарын байдлаар....28
Зураг 26. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2022 оны VI сарын байдлаар....29
Зураг 27. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2022 оны VI сарын байдлаар....29
Зураг 28. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2022 оны VI сарын байдлаар....30
Зураг 29. Ногоон ажлын байр хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2022 оны VI сарын байдлаар....30
Зураг 30. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2022 оны VI сарын байдлаар....31
Зураг 31. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоор осолдогчид, хэлбэр, улирлаар....32
Зураг 32. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан шалтгаан, 2022 оны II улирал....32
Зураг 33. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоор осолдогчид, учирсан гэмтлийн төрлөөр, 2022 оны II улирал....33
Зураг 34. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, гарсан цагаар, 2022 оны II улирал....33
Зураг 35. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого хамгийн их гарсан 5 салбар, улирлаар....34
Зураг 36. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан хүчин зүйл, хувиар, 2022 оны II улирал....34

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД-2022 ОНЫ I УЛИРАЛ

2022 оны I улирлын байдлаар арван тав, түүнээс дээш насны хүн амын **1 232.9** мянга (58.0 хувь) нь ажиллах хүч, **892.8** мянга (42.0 хувь) нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна.

АЖИЛЛАХ ХҮЧ

58.0%

1 232.9 МЯНГА

91.5% Ажиллагчид

8.5% Ажилгүй хүн

АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ

42.0%

892.8 МЯНГА

35.9% Тэтгэвэрт

27.3% Суралцдаг

36.8% Бусад

АЖИЛЛАГЧДЫН ТОО, мянган хүн

2021 I	52.5%	47.5%	1 054.9
2022 I	53.4%	46.6%	1 128.4

7.0% Өмнөх оны мөн үеэс

ХАМГИЙН ИХ АЖИЛЛАГЧИДТАЙ 3 САЛБАР

300.0 мянга **(26.6%)**

Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур

57.9% 173.6 мянга

42.1% 126.4 мянга

135.3 мянга **(12.0%)**

Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн завсар, үйлчилгээ

40.6% 54.9 мянга

59.4% 80.4 мянга

106.1 мянга **(9.4%)**

Боловсруулах үйлдвэрлэл

52.5% 55.8 мянга

47.5% 50.3 мянга

АЖИЛГҮЙ ИРГЭД

2021 I	59.2%	40.8%	101.2 мянга
2022 I	64.0%	36.0%	104.4 мянга

3.2% Өмнөх оны мөн үеэс

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үндэсний статистикийн хорооны Ажиллах хүчний судалгааны 2022 оны II улирлын дүнгээс харахад арван тав, түүнээс дээш насны хүн 2128.8 мянган хүн байгаагийн 1263.4 мянга (59.3 хувь) нь **ажиллах хүч**, 865.4 мянга (40.7 хувь) нь **ажиллах хүчнээс гадуурх хүн ам** байна. Хөдөлмөрийн насны хүн ам өмнөх оны мөн үеэс 4.8 мянга буюу 0.2 хувиар, өмнөх улирлаас 3.0 мянга буюу 0.1 хувиар нэмэгдсэн байна.

Нийт ажиллах хүчний 54.0 хувь нь эрэгтэйчүүд, 46.0 хувь нь эмэгтэйчүүд байна. Харин ажиллах хүчнээс гадуурх хүн амын 37.7 хувь нь эрэгтэйчүүд, 62.3 хувь эмэгтэйчүүд байна

Зураг 1. Ажиллах хүч, ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо, мянган хүн, 2022 оны II улирал



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 56.4 мянгаар, өмнөх улирлаас 30.5 мянгаар нэмэгдсэн байна.

Ажиллах хүчний 1164.9 мянга (92.2 хувь) нь **ажиллагчид,** 98.5 мянга (7.8 хувь) нь **ажилгүйчүүд** байна. Ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 59.1 мянгаар (5.4 хувь), өмнөх улирлаас 36.5 мянгаар (3.2 хувь) нэмэгдсэн байна. Харин ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 2.7 мянгаар (2.7 хувь), өмнөх улирлаас 5.9 мянгаар (5.6 хувь) буурсан дүнтэй байна.

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам өмнөх оны мөн үеэс 51.5 мянга буюу 5.6 хувиар буурсан бол мөн хугацаанд боломжит ажиллах хүч 27.2 мянга буюу 37.9 хувиар, бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам 24.3 мянга буюу 2.9 хувиар буурсан байна.

Хөдөлмөрийн дутуу ашиглалт буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байгаа хүн ам 2022 оны II улирлын байдлаар улсын хэмжээнд 149.4 мянга болж, өмнөх оны мөн үеэс 15.0 хувиар, өмнөх улирлаас 3.6 хувиар буурсан. Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг бүтцээр нь авч үзвэл, 98.5 мянга (66.0 хувь) нь **ажилгүй хүн,** 6.3 мянга (4.2 хувь) нь **цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч,** 44.6 мянга (29.8 хувь) нь **боломжит ажиллах хүч** байна.

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч өмнөх оны мөн үеэс 3.5 мянгаар буюу 2.2 дахин байна.

Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, мянган хүн

Үзүүлэлт	2021				2022		Өсөлт/Бууралт (Өмнөх)	
	I	II	III	IV	I	II	Он	Улирал
Ажиллах хүч	1156.1	1207.0	1226.8	1226.5	1232.9	1263.4	56.4	30.5
Үүнээс: эмэгтэй	542.4	561.4	582.5	583.6	563.4	581.6	20.2	18.2
Ажиллагчид	1054.9	1105.7	1135.9	1127.1	1128.4	1164.9	59.2	36.5
Үүнээс: эмэгтэй	501.1	513.1	539.6	540.3	525.7	541.1	28.1	15.4
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	6.3	2.8	8.3	6.8	4.0	6.3	3.5	2.3
Үүнээс: эмэгтэй	2.8	1.2	3.7	3.9	1.4	3.6	2.4	2.2
Ажилгүй хүн	101.2	101.3	90.9	99.4	104.4	98.5	-2.7	-5.9
Үүнээс: эмэгтэй	41.3	48.3	42.9	43.3	37.6	40.5	-7.9	2.9
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	949.7	917.0	893.8	878.2	892.8	865.4	-51.6	-27.4
Үүнээс: эмэгтэй	588.0	579.5	569.4	541.5	555.3	539.4	-40.1	-15.9
Боломжит ажиллах хүч	108.8	71.8	54.2	45.1	46.5	44.6	-27.2	-1.9
Үүнээс: эмэгтэй	54.8	38.1	30.1	20.5	23.7	18.7	-19.3	-5.0
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	840.9	845.1	839.6	833.1	846.3	820.8	-24.4	-25.5
Үүнээс: эмэгтэй	533.1	541.4	539.2	521.0	531.6	520.7	-20.7	-10.9
Хөдөлмөрийн дутуу ашиглалт	216.3	175.8	153.4	151.3	155.0	149.4	-26.4	-5.6
Үүнээс: эмэгтэй	98.9	87.6	76.8	67.7	62.7	62.8	-24.8	0.1

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

2021 оны II улирлаас цар тахлын хорио, хязгаарлалтыг сулруулснаас хойш ажиллагчдын тоо нэмэгдсэнээр 2022 оны II улиралд 1164.9 мянгад хүрч, 2021 оны II улиралтай харьцуулахад 59.2 мянгаар өссөн хэдий ч 2020 оны мөн үеийн түвшинд хүрээгүй хэвээр байна.

Зураг 2. Ажиллагчид, ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

2022 оны II улиралд ажил хөдөлмөр эрхэлж байгаа 100 хүн тутмын 46 нь (46.3 хувь) хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна. Хөдөө

аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар нь хөдөлмөр эрхлэлтийн дөрөвний нэгийг бүрдүүлдэг хамгийн том салбар хэвээр байна.

Зураг 3. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүн, 2022 оны II улирал

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Өмнөх оны мөн үеэс ажиллагчдын тоо нь хамгийн их өссөн салбаруудыг авч үзвэл, боловсруулах үйлдвэрлэл 24.4 мянгаар, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 14.3 мянгаар, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 12.9 мянгаар, боловсрол 9.7 мянгаар, урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбар 7.9 мянгаар тус бүр нэмэгджээ.

Харин өмнөх оны мөн үеэс ажиллагчдын тоо нь хамгийн их буурсан салбарууд бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ 11.3 мянгаар, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ 10.1 мянгаар, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 5.1 мянгаар тус бүр буурсан байна.

Зураг 4. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбар, өмнөх оны мөн үеэс, мянган хүн, 2022 оны II улирал



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын тоог хүйсээр харвал өмнөх оны мөн үеэс хөдөө аж ахуйн салбарт ажиллагчдын тоо 4.1 мянгаар буурсан бол үүний 1.7 мянган ажиллагчид нь эрэгтэй, 2.4 мянган ажиллагчид нь эмэгтэй байна. Үйлдвэрлэл болон үйлчилгээний бусад салбарт эрэгтэй эмэгтэй ажиллагчдын тоо өсөлттэй байгаа бөгөөд үйлдвэрлэлийн салбарт эрэгтэй ажиллагчдын тоо давалмгайлж байгаа бол үйлчилгээний салбарт эмэгтэй ажиллагчдын өсөлт илүү байна.

Зураг 5. Ажиллагчдын тооны өөрчлөлт, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн 3 салбараар, хүйсээр, өмнөх оны мөн үеэс, мянган хүн, 2022 оны II улирал



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын 794.8 мянга (68.2 хувь) нь хот, суурин газарт, 370.1 мянга (31.8 хувь) нь хөдөө орон нутагт байна. Ажиллагчдыг бүсээр авч үзвэл 529.6 мянга (45.5% хувь) нь Улаанбаатар хотод, 144.7 мянга (12.4% хувь) нь Баруун бүсэд, 226.9 мянга (19.5% хувь) нь Хангайн бүсэд, 175.8 мянга (15.1% хувь) нь Төвийн бүсэд, 87.9 мянга (7.5% хувь) нь Зүүн бүсэд байна. Ажиллагчдын тооны өөрчлөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Хангайн бүс 9.8 мянгаар (4.3 хувь), Төвийн бүс 6.2 мянгаар (3.5 хувь), Улаанбаатар хот 69.0 мянгаар (13.0 хувь) нэмэгдсэн бол Баруун бүс 18.5 мянгаар (12.8 хувь), Зүүн бүс 7.3 мянгаар (8.2 хувь) буурсан байна.

Зураг 6. Ажиллагчдын тоо, хот, хөдөө, бүсээр, 2022 оны II улирал



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

2022 оны II улирлын байдлаар ажилгүй иргэдийн 58.1 мянга (58.9 хувь) нь эрэгтэй, 40.5 мянга (41.1 хувь) нь эмэгтэйчүүд байна. Өөрөөр хэлбэл ажилгүй байгаа 10 хүн тутмын зургаа нь эрэгтэйчүүд байна.

Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 2.8 мянга буюу 2.7 хувиар буурчээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ажилгүй эрэгтэйчүүд 5.2 мянга буюу 9.8 хувиар нэмэгдсэн бол эмэгтэйчүүд 7.8 мянга буюу 16.2 хувиар буурсан байна.

Ажилгүйчүүдийн тоог бүсээр авч үзвэл Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 29.4 хувь нь, Хангайн бүсэд 27.5 хувь нь, Баруун бүсэд 23.2 хувь нь, Төвийн бүсэд 13.7 хувь нь, Зүүн бүсэд 6.2 хувь нь байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Хангайн бүс 12.6 мянгаар, Баруун бүс 3.7 мянгаар, Зүүн бүс 1.7 мянгаар нэмэгдсэн бол Төвийн бүс 4.1 мянгаар, Улаанбаатар хот 16.5 мянгаар буурчээ.

Мөн ажилгүйчүүдийн тоог насны бүлгээр авч үзвэл 13.1 мянга (13.3 хувь) нь 15-24 насны, 32.2 мянга (32.7 хувь) нь 25-34 насны, 26.0 мянга (26.3 хувь) нь 35-44 насны, 22.0 мянга (22.3 хувь) нь 45-54 насны, 5.3 мянга (5.4 хувь) нь 55, түүнээс дээш насны хүн байна. Ажилгүйчүүдийн тоо буурахад 15-24 насны залуучууд голлон нөлөөлсөн ба өмнөх оны мөн үеэс 4.5 мянга буюу 25.5 хувиар буурчээ. Харин эсрэгээр, 35-44 насны, 55, түүнээс дээш насны ажилгүйчүүдын тоо өмнөх оны мөн үеэс 2.6-3.6 мянгаар нэмэгдсэн байна.

Зураг 7. Ажилгүй хүний тоо, өөрчлөлт, өмнөх оны мөн үеэс, мянган хүн



Хүснэгт 2. Ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн

Үзүүлэлт		2021				2022		Өсөлт/Бууралт (Өмнөх)	
		I	II	III	IV	I	II	Он	Улирал
Бүгд		101.2	101.3	90.9	99.4	104.4	98.5	-2.8	-5.9
Хүйс	Эрэгтэй	59.8	52.9	48.0	56.1	66.8	58.1	5.2	-8.7
	Эмэгтэй	41.3	48.3	42.9	43.3	37.6	40.4	-7.8	2.9
Насны бүлэг	15-24	24.9	17.6	18.8	17.9	18.6	13.1	-4.5	-5.5
	25-34	35.7	35.4	26.0	29.8	32.4	32.2	-3.2	-0.2
	35-44	20.8	23.4	24.5	25.1	31.9	26.0	2.6	-6.0
	45-54	15.3	23.2	18.0	20.6	17.1	22.0	-1.2	4.9
	55+	4.5	1.7	3.5	5.9	4.4	5.3	3.6	0.9
Бүс	Баруун	17.6	19.1	13.4	12.2	20.4	22.8	3.7	2.5
	Хангайн	13.9	14.6	24.5	27.2	21.4	27.2	12.6	5.8
	Төвийн	18.1	17.6	19.1	18.5	13.7	13.5	-4.1	-0.2
	Зүүн	5.2	4.4	2.4	4.9	3.8	6.1	1.7	2.3
	Улаанбаатар	46.4	45.5	31.5	36.7	45.2	29.0	-16.5	-16.2

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажилгүйчүүдийн 41.2 хувь нь бүрэн дунд болон түүнээс доош түвшний, 18.5 хувь нь техникийн болон мэргэжлийн, тусгай мэргэжлийн дунд, 40.3 хувь нь дипломын болон бакалавр, түүнээс дээш түвшний боловсролтой байна.

Зураг 8. Ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 7.8 хувь болж, өмнөх улирлаас 0.7 пунктээр, өмнөх оны мөн үеэс 0.6 пунктээр буурсан. Энэ хугацаанд эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 7.0 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.6 пунктээр буурч, харин эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 8.5 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр өссөн байна. Мөн 15-24 насны залуучуудын хувьд 12.2 хувь буюу өмнөх оны мөн үеэс 4.9 хувь буурсан бол 25-34 насны залуучуудын хувьд 9.3 хувь буюу өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар буурсан байна.

Зураг 9. Ажиллагчдын тоо, ажилгүйдлийн түвшин, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Хөдөлмөрийн насны хүн амд ажиллах хүчний нийлүүлэлтийн эзлэх хувийг илэрхийлэх түвшин бүхий **ажиллах хүчний оролцооны түвшинг** улирлаар авч үзэхэд 2022 оны II улиралд 59.3 хувь болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 пунктээр өссөн хэдий ч Ковид цар тахлын өмнөх үе буюу 2018, 2019 оны мөн үеэс 1.5-1.7 пунктээр бага байсаар байна.

Хөдөлмөрийн нөөцөд ажиллагчдын эзлэх хувь буюу хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2022 оны II улирлын байдлаар 54.7 хувь болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.6 пунктээр өссөн нь цар тахлын өмнөх үе буюу 2019 оны мөн үетэй ойролцоо байна.

Зураг 10. Ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД-2022 ОНЫ II УЛИРАЛ

ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ ААНБ

2021 II улирал
48 738

2022 II улирал
51 776
6.2% Өмнөх оны мөн үеэс

ААНБ-ын төрлөөр

Хувийн ААНБ
91.0%
47.0 мянга

Төсөвт
9.0%
4.7 мянга

ТЭТГЭВЭР АВАГЧИД

2021 II улирал
451.8 мянга

2022 II улирал
467.4 мянга
3.4% Өмнөх оны мөн үеэс

77.9% Өндөр насны тэтгэвэр

4.2% Тэжээгчээ алдсаны тэтгэвэр

13.6% Тахир дутуугийн тэтгэвэр

4.3% Цэргийн тэтгэвэр

ШИМТГЭЛИЙН ОРЛОГО

Тэтгэвэр
83.7%
1026.0 тэрбум

Тэтгэмж
8.1%
99.0 тэрбум

1125.1 тэрбум
30.0% Өмнөх оноос

Ажилгүйдэл
1.5%
18.6 тэрбум

ҮОМШӨ*
6.7%
81.5 тэрбум

* Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

ДААТГУУЛАГЧ

2021 II улирал
962.4 мянга

7.0% Өмнөх оны мөн үеэс

2022 II улирал
1029.9 мянга

☑ Даатгуулагчид, төрлөөр

Албан журам
87.1%
896.7 мянга

Сайн дур
12.9%
133.2 мянга

САЙН ДУРААР ДААТГУУЛАГЧ

12.7% Малчид
17.0 мянга
34.7% Өмнөх оны мөн үеэс

4.2% Хувиараа
5.5 мянга
43.2% Өмнөх оны мөн үеэс

ЗАРЛАГА

Тэтгэвэр
92.2%
1466.4 тэрбум

Тэтгэмж
4.7%
74.2 тэрбум

1590.4 тэрбум
27.3% Өмнөх оноос

Ажилгүйдэл
2.1%
33.5 тэрбум

ҮОМШӨ*
1.0%
16.3 тэрбум

Мэдээллийн эх үүсвэр: НДЕГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2022 оны II улирлын байдлаар шимтгэл төлөгч байгууллагын тоо 51.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 3.0 мянга буюу 6.2 хувиар өссөн байна. Нийт шимтгэл төлөгч байгууллагын 91.0 хувь нь хувийн аж ахуй нэгж байгууллага, 9.0 хувь нь төсөвт байгууллагууд байна. Хувийн аж ахуй нэгж байгууллагын тоо өмнөх оны мөн үеэс 2.9 мянга буюу 6.7 хувиар, төсөвт байгууллагын тоо 79 буюу 1.7 хувиар нэмэгджээ.

Мөн 2022 оны II улирлын байдлаар нийгмийн даатгалд 1029.9 мянган даатгуулагч даатгуулсан бөгөөд 133.2 мянга (12.9 хувь) нь сайн дурын, 896.7 мянга (87.1 хувь) нь албан журмын даатгуулагч байна. Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 67.5 мянга буюу 7.0 хувиар нэмэгджээ.

Хүснэгт 3. Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч байгууллага, даатгуулагч, улирлаар

Улирал	Шимтгэл төлөгч ААНБ			Даатгуулагч		
	Нийт	Хувийн ААНБ	Төсөвт байгууллага	Нийт	Сайн дур	Албан журам
2020 I	42862	38286	4576	831943	108042	723901
II	46762	42185	4577	961692	156624	805068
III	47818	43225	4593	1051309	172892	878417
IV	49067	44442	4625	1156793	192090	964703
2021 I	46242	41668	4574	845802	100956	744846
II	48738	44137	4601	962387	136141	826246
III	50625	46001	4624	1062030	147827	914203
IV	52388	47732	4656	1181282	161111	1020171
2022 I	48462	43807	4655	891825	107417	784354
II	51776	47096	4680	1029922	133167	896755

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Албан журмын даатгуулагч өмнөх оны мөн үеэс 70.5 мянга буюу 8.5 хувиар нэмэгдсэн бол сайн дурын дурын даатгуулагч 2.9 мянга буюу 2.2 хувиар буурсан дүнтэй байна.

Албан журмын даатгуулагчдын 633.2 мянга (70.6 хувь) нь хувийн аж ахуй нэгж байгууллагын, 244.4 мянга (29.4 хувь) нь төсөвт байгууллагын ажиллагчид байна. Өмнөх оны мөн үеэс хувийн аж ахуй нэгж байгууллагын даатгуулагч 61.0 мянгаар (10.7 хувь), төсөвт байгууллагын даатгуулагч 9.5 мянгаар (3.7 хувь) нэмэгдсэн.

Зураг 11. Даатгуулагчийн тоо, төрөл, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Сайн дурын даатгуулагчдыг гол төрлөөр нь авч үзвэл 17.0 мянга (12.7 хувь) нь малчид, 5.5 мянга (4.2 хувь) нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, үлдсэн 110.7 мянга (83.1 хувь) нь бусад төрлийн даатгуулагч байна. Даатгалд хамрагдсан малчдын тоо өмнөх оны мөн үеэс 9.0 мянга буюу 34.7 хувиар, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 4.2 мянга буюу 43.2 хувиар буурчээ.

Засгийн газраас хэрэгжүүлсэн Ковид-19 цар тахлын хариу арга хэмжээний хүрээнд 2020 оны 4 дүгээр сарын 1-нээс 2020 оны 10 дугаар сарын 1-нийг хүртэлх хугацаанд сайн дурын даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн чөлөөлөх дэмжлэг үзүүлсэн нь 2020 онд сайн дурын даатгалд хамрагдсан даатгуулагчдын тоо буурахаас сэргийлж чадсан. Харин 2021 он гарснаас хойш сайн дураар даатгуулсан хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдын тоо цар тахлын өмнөх үетэй харьцуулахад буурсан хэвээр байна.

Зураг 12. Сайн дураар даатгуулсан хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдын тоо, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Тэтгэврийн даатгалын сангаас **тэтгэвэр авсан иргэд** 2022 оны II улирлын байдлаар 467.4 мянга болж, өмнөх оны мөн үеэс 15.6 мянга буюу 3.4 хувиар нэмэгджээ. Тэтгэвэр авсан иргэдийн 77.9 хувь нь **өндөр насны тэтгэвэр,** 13.6 хувь нь **тахир дутуугийн тэтгэвэр,** 4.2 хувь нь **тэжээгчээ алдсаны тэтгэвэр,** 4.3 хувь **цэргийн тэтгэвэр** авсан байна.

Өндөр насны тэтгэвэр авсан иргэд 2022 оны II улирлын байдлаар 364.2 мянга болж, өмнөх оны мөн үеэс 16.9 мянга буюу 4.9 хувиар, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авсан иргэд 19.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 248 буюу 1.3 хувиар, цэргийн тэтгэвэр авсан иргэд 20.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 669 буюу 3.4 хувиар нэмэгдсэн бол тахир дутуугийн тэтгэвэр авсан иргэд 63.5 мянга болж, өмнөх оны мөн үеэс 2.2 мянга буюу 3.5 хувиар буурчээ.

Хүснэгт 4. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэдийн тоо, төрөл, улирлаар

Улирал	Тэтгэвэр авагчдын тоо	Үүнээс:			
		Өндөр насны тэтгэвэр	Тахир дутуугийн тэтгэвэр	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	Цэргийн тэтгэвэр
2020 I	427,247	320,602	67,912	19,853	18,880
II	434,186	327,799	67,663	19,711	19,013
III	439,481	333,026	67,769	19,584	19,102
IV	444,788	338,982	67,018	19,553	19,235

2021 I	449,419	344,287	66,344	19,511	19,277
II	451,845	347,235	65,771	19,377	19,462
III	454,298	350,091	65,197	19,437	19,573
IV	456,365	353,775	63,318	19,563	19,709
2022 I	462,607	359,783	63,439	19,588	19,797
II	467,420	364,173	63,491	19,625	20,131

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Зураг 13. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэд, төрлөөр, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Тэтгэмжийн даатгалын сангаас **тэтгэмж авсан иргэд** 2022 оны II улирлын байдлаар 122.2 мянга болж, өмнөх оны мөн үеэс 37.6 мянга буюу 44.4 хувиар нэмэгдсэн байна. Тэтгэмж авсан иргэд 72.6 хувь нь **хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж,** 21.6 хувь нь **жирэмсний болон амаржсаны тэтгэмж,** 5.8 хувь нь **оршуулгын тэтгэмж** авсан байна.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авсан иргэд 2022 оны II улирлын байдлаар 88.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1 дахин, оршуулгын тэтгэмж авсан иргэд 7.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 258 буюу 3.8 хувиар нэмэгдсэн бол жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан иргэд 26.4 мянга болж, өмнөх оны мөн үеэс 7.6 мянга буюу 22.3 хувиар буурчээ.

Зураг 14. Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авсан иргэдийн тоо, төрлөөр



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас **тэтгэвэр, тэтгэмж** авсан иргэд 2022 оны II улирлын байдлаар 5.3 мянга болж, өмнөх оны мөн үеэс 0.5 мянга буюу 9.8 хувиар, өмнөх улирлаас 0.7 мянга буюу 15.9 хувиар нэмэгдсэн байна. ҮОМШӨ-ны даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэдийн 68.5 хувь нь **тахир дутуугийн тэтгэвэр,** 8.7 хувь нь **тэжээгчээ алдсаны тэтгэвэр,** 9.8 хувь нь **тэтгэмж, төлбөр,** 13.0 хувь нь **ҮОМШӨ-ний сувилалд** хамрагдсан байна.

Зураг 15. ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэд, төрлөөр, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 2022 оны II улирлын байдлаар 1225.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 283.0 тэрбум төгрөг буюу 30.0 хувиар, **нийгмийн даатгалын зарлага** 1590.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 341.2 тэрбум төгрөг буюу 27.3 хувиар нэмэгдсэн.

2022 оны II улирлын байдлаар шимтгэлийн орлогын 83.7 хувийг тэтгэврийн даатгалын сан, 8.1 хувийг тэтгэмжийн даатгалын сан, 6.7 хувийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан, 1.5 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого бүрдүүлж байна. Харин нийгмийн даатгалын зарлагын 92.2 хувийг тэтгэврийн даатгалын сан, 4.7 хувийг тэтгэмжийн даатгал сан, 1.0 хувийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан, 2.1 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага эзэлж байна.

Хүснэгт 5. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт	2021 II		2022 II		Өөрчлөлт	
		Эзлэх хувь		Эзлэх хувь	Тоо	Хувь
НД-ын шимтгэлийн орлого	942.1	100.0%	1225.1	100.0%	283.0	30.0%
Тэтгэвэр	822.6	87.3%	1026.0	83.7%	203.4	24.7%
Тэтгэмж	57.4	6.1%	99.0	8.1%	41.6	72.5%
ҮОМШӨ	49.4	5.2%	81.5	6.7%	32.1	65.0%
Ажилгүйдэл	12.7	1.3%	18.6	1.5%	6.0	47.2%
НД-ын зарлага	1249.2	100.0%	1590.4	100.0%	341.2	27.3%
Тэтгэвэр	1128.5	90.3%	1466.4	92.2%	337.9	29.9%
Тэтгэмж	80.0	6.4%	74.2	4.7%	-5.8	-7.3%
ҮОМШӨ	14.1	1.1%	16.3	1.0%	2.2	15.6%
Ажилгүйдэл	26.6	2.1%	33.5	2.1%	6.9	25.9%

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Ажилгүйдлийн тэтгэмжид 2022 оны II улирлын байдлаар 14.4 мянган иргэн хамрагдсан бөгөөд тэтгэмж болгож 33.5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан иргэд өмнөх оны мөн үеэс 2.1 мянга буюу 17.6 хувиар, тэтгэмжид зарцуулсан хөрөнгө 6.9 тэрбум төгрөг буюу 25.7 хувиар нэмэгджээ.

2021 оны II улиралд ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан нэг хүнд дунджаар 2.2 сая төгрөгийг зарцуулж байсан бол 2022 оны II улиралд 2.3 сая болж, 6.9 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 16. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан хүн, зарцуулсан хөрөнгө, улирлаар

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

САРЫН ДУНДАЖ ЦАЛИНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Аж ахуй нэгж байгууллагын **ажиллагчдын сарын дундаж цалин** 2022 оны I улирлын байдлаар 1450.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 135.2 мянга буюу 10.3 хувиар, өмнөх улирлаас 11.9 мянга буюу 0.8 хувиар өссөн байна. Тухайн өсөлт нь нэрлэсэн дундаж цалингийн өсөлт бөгөөд бодит цалинийн өсөлт биш юм.

Ажиллагчдын сарын дундаж цалинг хүйсээр авч үзвэл, эрэгтэйчүүд 1577.3 мянган төгрөг, эмэгтэйчүүд 1317.7 мянган төгрөгийн цалинтай байна. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн цалингийн зөрүү 2022 оны I улиралд 259.6 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 14.2 мянгаар буурчээ.

Өөрөөр хэлбэл 2022 оны I улирлын байдлаар эмэгтэйчүүдийн дундаж цалин эрэгтэйчүүдийн дундаж цалингийн 83.5 хувьтай тэнцэж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 4.2 пунктээр өссөн нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн цалингийн ялгаа буурч байгааг харуулж байна.

Хүснэгт 6. Ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, мянган төгрөг

Үзүүлэлт	2021				2022 I	Өсөлт/Бууралт (өмнөх)	
	I	II	III	IV		Он	Улирал
Дундаж цалин	1314.9	1330.4	1335.1	1438.2	1450.1	135.2	11.9
Эрэгтэй	1461.5	1439.9	1462.5	1549.6	1577.3	115.8	27.7
Эмэгтэй	1158.9	1212.8	1201.7	1320.4	1317.7	158.8	-2.7

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Медиан цалин гэдэг ажиллагчдын цалинг өсөх эсвэл буурах эрэмбээр байршуулсан цувааг таллан хуваах байгаа ажилтны цалин юм. 2022 оны I улирлын байдлаар медиан цалин 1066.7 мянга болж, өмнөх оны мөн үеэс 121.0 мянга буюу 12.8 хувиар нэмэгдсэн бол өмнөх улирлаас 1.4 мянга буюу 0.1 хувиар буурсан байна.

2022 оны I улирлын байдлаар нийгмийн даатгалд шимтгэл төлсөн ажиллагчдыг цалин хөлсний бүтцээр авч үзвэл 26.8 хувь нь 700.0 мянга хүртэлх төгрөг, 25.2 хувь нь 700.0 мянга-1.1 сая төгрөг, 19.2 хувь нь 1.1-1.5 сая төгрөг, 12.3 хувь нь 1.5-2.0 мянган төгрөг, 9.4 хувь нь 2.0-3.0

мянган төгрөг, 7.1 хувь нь 3.0 саяас дээш мянган төгрөгийн цалинтай ажиллагчид байна.

Нийгмийн даатгалд шимтгэл төлсөн ажиллагчдын 71.2 хувь нь дундаж цалинтай ойролцоо эсвэл доогуур цалин хөлстэй байна.

Зураг 17. Дундаж болон медиан цалин, мянган төгрөг, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

2022 оны I улирлын байдлаар 1-9 ажиллагчидтай байгууллагын дундаж цалин улсын дунджаас 542.3 мянгаар, 10-49 ажиллагчидтай байгууллагынх 272.8 мянгаар, 50-99 ажиллагчидтай байгууллагынх 152.4 мянгаар бага байгаа бол 100-199 ажиллагчидтай байгууллагынх 11.7 мянгаар, 200,түүнээс дээш ажиллагчидтай байгууллагынх 587.3 мянган төгрөгөөр өндөр байна.

Дундаж цалингийн өөрчлөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд 1-49 хүртэлх ажиллагчидтай байгууллагын ажиллагчдын дундаж цалин хамгийн их буюу 10.4-10.6 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Ажиллагчдын сарын дундаж цалин, ажиллагчдын тооны бүлэг, хүйсээр, мянган төгрөг

Ажиллагчдын тооны бүлэг	2021 I			2022 I			Өөрчлөлт	
		Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй	Тоо	Хувь
Бүгд	1330.4	1439.9	1212.8	1450.1	1577.3	1317.7	119.7	9.0%
1-9	821.0	833.8	808.2	907.8	914.2	901.5	86.8	10.6%
10-49	1066.3	1076.9	1056.6	1177.3	1172.1	1181.9	111.0	10.4%
50-99	1223.2	1286.5	1162.8	1297.7	1370.2	1232.9	74.5	6.1%
100-199	1374.9	1425.3	1319.6	1461.8	1534.3	1387.6	86.9	6.3%
200 дээш	1867.1	2057.8	1604.4	2037.4	2260.8	1731.1	170.3	9.1%

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын сарын дундаж цалинг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзэхэд уул уурхай, олборлолтын салбарт ажиллагчдын дундаж цалин хамгийн их (3463.9 мянга), урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбарт ажиллагчдын дундаж цалин хамгийн бага (919.1 мянга) байна.

Уул уурхай, олборлолтын салбарын ажиллагчдын дундаж цалин улсын дунджаас 2013.8 мянга буюу 138.9 хувиар их байгаа бол урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбарт ажиллагчдын дундаж цалин улсын дунджаас 531.0 мянга буюу 36.6 хувиар бага байна. Тоон мэдээллээс харахад 2015 оны I улирлаас эхлэн уул уурхай, олборлолтын салбарын ажиллагчдын дундаж цалин улсын дунджаас нэг дахин их болсон байна.

Өмнөх оны мөн үеэс сарын дундаж цалин хамгийн их нэмэгдсэн 3 салбарыг авч үзвэл санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 325.1 мянган (21.4 хувь), хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа 282.2 мянган (25.5 хувь), мэдээлэл, холбоо 229.7 мянган (17.5 хувь) төгрөгөөр нэмэгдсэн байна.

Зураг 18. Ажиллагчдын сарын дундаж цалин, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, улирлаар

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ-2022 ОНЫ II УЛИРАЛ

АЖИЛ ХАЙГЧ ИРГЭН

24 184

10.4% Өмнөх оны мөн үеэс

49.6% Эмэгтэй

2.2% Хөгжлийн бэрхшээлтэй

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН

16 282

7.8% Өмнөх оны мөн үеэс

50.4% Эмэгтэй

2.0% Хөгжлийн бэрхшээлтэй

АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА

24 320

19.5% Өмнөх оны мөн үеэс

56.2% Эрэлт хангасан хувь

0.1% Өмнөх оны мөн үеэс

АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭН

13 670

19.7% Өмнөх оны мөн үеэс

49.1% Эмэгтэй

Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ

ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, улсаар

6 206 Гадаадын иргэд = **5 535** (89.2%) Эрэгтэй + **671** (10.8%) Эмэгтэй



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор **ажил хайж байгаа иргэдийн** тоо 2022 оны II улирлын эцэст 24.2 мянга болж, өмнөх оны мөн үеэс 2.8 мянга буюу 10.4 хувиар буурсан байна. Ажил хайж байгаа иргэдийн 12.1 мянга (50.1 хувь) нь эрэгтэйчүүд, 12.1 мянга (49.9 хувь) нь эмэгтэйчүүд байна. Ажил хайж байгаа иргэдийг насны бүлгээр авч үзвэл, 3.0 мянга (12.4 хувь) нь 15-24 насны, 8.5 мянга (35.2 хувь) нь 25-34 насны, 7.1 мянга (29.2 хувь) нь 35-44 насны, 4.3 мянга (17.8 хувь) нь 45-54 насны, 1.3 мянга (5.3 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.

Харин тухайн үед ажилгүй байгаа, ажил идэвхтэй хайж хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн **бүртгэлтэй ажилгүй иргэний** тоо 16.3 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.3 мянга буюу 7.8 хувиар буурсан байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 8.1 мянга (49.6 хувь) нь эрэгтэйчүүд, 8.2 мянга (50.4 хувь) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны бүлгээр авч үзвэл, 2.2 мянга (13.3 хувь) нь 15-24 насны, 6.0 мянга (36.6 хувь) нь 25-34 насны, 4.6 мянга (28.5 хувь) нь 35-44 насны, 2.7 мянга (16.3 хувь) нь 45-54 насны, 0.9 мянга (5.3 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.

Хүснэгт 8. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар

Улирал	Ажил хайгч / сарын эцэст/			Бүртгэлтэй ажилгүй иргэн /сарын эцэст/		
		Эмэгтэй	Эзлэх хувь		Эмэгтэй	Эзлэх хувь
2020 I	31785	16285	51.2%	19394	10009	51.6%
II	30320	15367	50.7%	19563	10001	51.1%
III	27504	14301	52.0%	17829	9446	53.0%
IV	29952	15390	51.4%	18103	9535	52.7%
2021 I	25105	12774	50.9%	16775	8650	51.6%
II	26991	13837	51.3%	17650	9202	52.1%
III	21804	11316	51.9%	15053	7895	52.4%
IV	27950	14510	51.9%	18644	9821	52.7%
2022 I	24255	12019	49.6%	16622	8345	50.2%
II	24184	12075	49.9%	16282	8210	50.4%

Зураг 19. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Ажил хайгч иргэдийн боловсролын түвшинг авч үзвэл, 1.3 хувь нь боловсролгүй, 2.1 хувь нь бага, 5.7 хувь нь суурь, 54.0 хувь нь бүрэн дунд, 6.1 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.5 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 25.3 дипломын болон бакалаврын дээд, 1.0 хувь нь магистр, түүнээс дээш түвшний боловсролтой байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр авч үзвэл, 1.2 хувь нь боловсролгүй, 1.9 хувь нь бага, 5.3 хувь нь суурь, 51.3 хувь нь бүрэн дунд, 6.5 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.5 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 28.2 дипломын болон бакалаврын дээд, 1.1 хувь нь магистр, түүнээс дээш түвшний боловсролтой байна.

Зураг 20. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролын түвшин, дүнд эзлэх хувиар, 2022 оны II улирал

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

2022 оны II улиралд 24.3 мянган ажлын байрны захиалга ирсэн бөгөөд 13.6 мянган иргэнийг ажилд зуучилж, эрэлтийн 56.2 хувийг хангажээ. Ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс 3.9 мянга буюу 19.5 хувиар, ажилд зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үеэс 2.2 мянга буюу 19.7 хувиар нэмэгдсэн байна.

Ажилд зуучлагдсан иргэдийг насны бүлгээр авч үзвэл, 2.6 мянга (19.1 хувь) нь 15-24 насны, 4.6 мянга (33.7 хувь) нь 25-34 насны, 3.5 мянга (25.6 хувь) нь 35-44 насны, 2.2 мянга (16.1 хувь) нь 45-54 насны, 0.8 мянга (5.5 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.

2022 оны II улиралд хөдөлмөрийн эрэлтийн 56.2 хувийг хангасан бөгөөд өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр, өмнөх улирлаас 14.4 пунктээр өсжээ.

Хүснэгт 9. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэн, улирлаар

Улирал	Ажлын байрны захиалга	Ажилд зуучлагдсан иргэн			Эрэлт хангасан хувь
			Эмэгтэй	Эзлэх хувь	
2020 I	7595	4489	2307	51.4%	59.1%
II	28036	15250	7330	48.1%	54.4%
III	42433	21672	10858	50.1%	51.1%
IV	58022	33006	16651	50.4%	56.9%
2021 I	6413	3066	1545	50.4%	47.8%
II	20352	11416	5542	48.5%	56.1%
III	32656	17636	9068	51.4%	54.0%

IV	51034	29929	15460	51.7%	58.6%
2022 I	9322	3901	2003	51.3%	41.8%
II	24320	13670	6709	49.1%	56.2%

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл, 2022 оны II улиралд ирсэн ажлын байрны захиалгын 58.0 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа (35.7 хувь), уул уурхай, олборлолт (14.2 хувь), барилгын (8.1 хувь) салбараас ирсэн байна.

2022 оны II улирлын байдлаар тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, боловсролын салбарын эрэлтийн 71.8 - 73.8 хувийг, мэдээлэл, холбооны салбарын эрэлтийн 91.5 хувийг хангасан байна.

Хүснэгт 10. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд, 2022 оны II улирал

Үзүүлэлт	Ажлын байрны захиалга	Эзлэх хувь	Ажилд зуучлагдсан иргэн	Эзлэх хувь	Эрэлт хангасан хувь
Бүгд	24320	100.0%	13670	100.0%	56.2%
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1884	7.7%	1083	7.9%	57.5%
Уул уурхай, олборлолт	3446	14.2%	1958	14.3%	56.8%
Боловсруулах үйлдвэрлэл	1276	5.2%	590	4.3%	46.2%
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	140	0.6%	91	0.7%	65.0%
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдал	228	0.9%	108	0.8%	47.4%
Барилга	1985	8.2%	1105	8.1%	55.7%
Бөөний болон жижиглэн худалдаа	954	3.9%	324	2.4%	34.0%
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	194	0.8%	141	1.0%	72.7%
Зочид буудал, байр, нийтийн хоолны үйлчилгээ	425	1.7%	167	1.2%	39.3%
Мэдээлэл, холбоо	355	1.5%	325	2.4%	91.5%
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	233	1.0%	133	1.0%	57.1%
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	55	0.2%	20	0.1%	36.4%
Мэргэжлийн ШУ болон техникийн үйл ажиллагаа	77	0.3%	56	0.4%	72.7%
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1050	4.3%	775	5.7%	73.8%
Төрийн удирдлага ба батлан хамгаалах	828	3.4%	443	3.2%	53.5%
Боловсрол	1332	5.5%	957	7.0%	71.8%
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	739	3.0%	464	3.4%	62.8%
Урлаг, үзвэр, тоглоом наадам	224	0.9%	129	0.9%	57.6%
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	8684	35.7%	4667	34.1%	53.7%
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	157	0.6%	104	0.8%	66.2%
ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	54	0.2%	30	0.2%	55.6%

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

ГАДААДААС АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТЭН АВАХ, ГАДААДАД АЖИЛЛАХ ХҮЧ ЗУУЧЛАХ

2022 оны II улирлын байдлаар **хөдөлмөрийн гэрээгээр гадаадын** 88 улсын 6206 иргэн ажил, хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэд өмнөх оны мөн үеэс 948 буюу 18.0 хувиар, өмнөх улирлаас 743 буюу 13.6 хувиар нэмэгджээ. Гэрээгээр ажил эрхэлж байгаа гадаадын иргэдийн 5535 (89.2 хувь) нь эрэгтэйчүүд, 671 (10.8 хувь) нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийн 37.2 хувь нь Улаанбаатар хотод, 36.1 хувь нь Төвийн бүсэд, 14.7 хувь нь Зүүн бүсэд, 6.9 хувь нь Баруун бүсэд, 5.1 хувь нь Хангайн бүсэд оршин сууж байна.

Мөн хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийг иргэншлээр нь авч үзвэл, 3748 (60.4 хувь) нь Хятад, 286 (4.6 хувь) нь Энэтхэг, 280 (4.5 хувь) нь Вьетнам, 266 (4.3 хувь) нь ОХУ, 225 (3.6 хувь) нь Өмнөд Солонгос, 183 (2.9 хувь) нь Австрали, 167 (2.7 хувь) нь АНУ, 164 (2.6 хувь) нь Өмнөд Африк, 150 (2.4 хувь) нь Филиппин, үлдсэн 737 (11.9 хувь) нь бусад улсын иргэн байна.

Зураг 21. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, хамгийн их 5 улсаар, дүнд эзлэх хувиар, 2022 оны II улирал



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

2022 оны II улирлын байдлаар 167 иргэн **хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажилд зуучлагдсан** бөгөөд өмнөх улирлаас 236 буюу 58.6 хувиар буурчээ.

Гадаадад ажилд зуучлагдсан иргэдийн 115 (68.9 хувь) нь Өмнөд Солонгос, 52 (31.1 хувь) нь Япон улсад зуучлагдсан. Ажилд зуучлагдсан иргэдийн 117 (70.1 хувь) нь эрэгтэйчүүд, 50 (29.9 хувь) нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажилд зуучлагдсан иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл, 12.0 хувь 20-24 насны, 17.4 хувь нь 25-29 насны, 37.7 хувь нь 30-34 насны, 24.0 хувь нь 35-39 насны, үлдсэн 9.0 хувь нь 40, түүнээс дээш насныхан байна.

Хөдөлмөрийн гэрээгээр гадаадад зуучлагдсан иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл, 32.9 хувь нь бүрэн дунд, 0.6 хувь нь суурь, 11.4 хувь нь техникийн болон мэргэжлийн, 55.1 хувь нь бакалаврын болон түүнээс дээш түвшний боловсролтой байна.

Зураг 22. Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэд, 2022 оны II улирал

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, ажил олгогч, залуучууд, эмэгтэйчүүд, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан зэрэг хөдөлмөрийн зах зээл дэх хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2022-2023 онд улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндсэн 7 хөтөлбөр, 28 арга хэмжээг хэрэгжүүлж байна.

2022 оны I-VI сарын байдлаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт 21.6 мянган иргэнийг хамруулж, 16.6 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэдийг хөтөлбөрийн төрлөөр авч үзвэл 23.1 хувь нь Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, 20.1 хувь нь Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр, 13.1 хувь нь Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 7.0 хувь нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 3.5 хувь нь Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 26.4 хувь нь Ногоон ажлын байр хөтөлбөр, 7.0 хувь нь Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан байна.

Зарцуулсан хөрөнгийг төсөл, хөтөлбөрөөр авч үзвэл 1.2 хувь нь Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, 49.3 хувь нь Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр, 0.4 хувь нь Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 23.4 хувь нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 15.0 хувь нь Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 10.3 хувь нь Ногоон ажлын байр хөтөлбөр, 0.4 хувь нь Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт зарцуулсан байна.

Зураг 23. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, сая төгрөг, 2022 оны VI сарын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт 2022 онд VI сарын байдлаар 5.0 мянган иргэн хамрагдаж, 200 иргэн байнгын ажлын байраар хангагдаж, 194.0 сая төгрөг зарцуулсан байна.

Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 51.2 хувь нь ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалт, 19.1 хувь нь ажилд зуучлах уулзалтад бэлтгэх, 29.7 хувь нь танхимын сургалт зохион байгуулах арга хэмжээнд хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 37.2 хувь нь ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалт, 17.0 хувь нь ажилд зуучлах уулзалтад бэлтгэх, 45.8 хувь танхимын сургалт зохион байгуулах арга хэмжээнд зарцуулсан байна.

Зураг 24. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2022 оны VI сарын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт 2022 онд VI сарын байдлаар 4.3 мянган иргэн хамрагдаж, 8,217.2 сая төгрөг зарцуулж, 1,625 ажлын байр бий болсон байна.

Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 48.3 хувь нь аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах, 21.7 хувь нь иргэн аж ахуй нэгжид санхүүгийн дэмжлэг олгох, 16.6 хувь нь борлуулалтын дэмжлэг, 11.5 хувь нь малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох, үлдсэн 1.9 хувь нь бусад арга хэмжээнд хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 82.5 хувь нь аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах, 15.2 хувь нь малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох, үлдсэн 2.3 хувь нь бусад арга хэмжээнд зарцуулсан.

Зураг 25. Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2022 оны VI сарын байдлаар

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2022 онд VI сарын байдлаар 1504 иргэн хамрагдаж, 74.4 сая төгрөгийг зарцуулж, байнгын 1843 ажлын байрыг бий болгосон байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 10.6 хувь нь ажлын дадал туршлага эзэмшүүлэх үйлчилгээ, 10.2 хувь нь гарааны бизнесийг дэмжих, 73.9 хувь нь цагийн ажилд зуучлах, 4.9 хувь нь залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвд сургалт зохион байгуулах арга хэмжээнд хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 4.8 хувь нь ажлын дадал туршлага эзэмшүүлэх үйлчилгээ, 62.6 хувь нь гарааны бизнесийг дэмжих, 24.5 хувь нь цагийн ажилд зуучлах, 8.1 хувь нь залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвд сургалт зохион байгуулах арга хэмжээнд зарцуулсан байна.

Зураг 26. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2022 оны VI сарын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2022 оны VI сарын байдлаар 752 иргэн хамрагдаж, 2497.4 сая төгрөгийг зарцуулж, 870 ажлын байрыг бий болгосон байна.

Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 11.4 хувь нь зөвлөх үйлчилгээнд, 75.5 хувь нь санхүүгийн дэмжлэг, 13.0 хувь нь хүүхэд хамгаалагч үйлчилгээнд хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 3.0 хувь нь зөвлөх үйлчилгээнд, 95.4 хувь нь санхүүгийн дэмжлэг, 1.6 хувь нь хүүхэд хамгаалагч үйлчилгээнд зарцуулсан байна.

Зураг 27. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2022 оны VI сарын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 2022 онд VI сарын байдлаар 1504 иргэн хамрагдаж, 3908.1 сая төгрөгийг зарцуулж, 622 ажлын байрыг бий болгосон байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 35.8 хувь нь иргэнд санхүүгийн дэмжлэг олгох, 4.8 хувь нь аж ахуйн нэгж байгууллагад санхүүгийн дэмжлэг олгох, 46.7 хувь нь аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах, 3.3

хувь нь борлуулалтын дэмжлэг үзүүлэх, 0.3 хувь нь урамшуулал дэмжлэг үзүүлэх, 9.0 хувь нь хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээнд хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 70.9 хувь нь иргэнд санхүүгийн дэмжлэг олгох, 26.7 хувь нь аж ахуйн нэгж байгууллагад санхүүгийн дэмжлэг олгох, үлдсэн 2.3 бусад арга хэмжээнд зарцуулсан байна.

Зураг 28. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2022 оны VI сарын байдлаар

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Ногоон ажлын байр хөтөлбөрт 2022 оны VI сарын байдлаар 5695 иргэн хамрагдаж, 1711.6 сая төгрөгийг зарцуулж, 5116 ажлын байрыг бий болгосон байна.

Ногоон ажлын байр хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 51.3 хувь нь нийтийг хамарсан ажил, 48.7 хувь нь мод тарих үйлчилгээнд хамрагдсан бол зарцуулсан хөрөнгийн 50.2 хувь нь нийтийг хамарсан ажил, 49.8 хувь нь мод тарих үйлчилгээнд зарцуулсан байна.

Зураг 29. Ногоон ажлын байр хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2022 оны VI сарын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2022 оны VI сарын байдлаар 1504 иргэн хамрагдаж, 65.5 сая төгрөгийг зарцуулж, 57 байнгын ажлын байр, 579 түр ажлын байрыг бий болгосон байна.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 0.3 хувь нь иргэнд санхүүгийн дэмжлэг олгох, 8.4 хувь нь богино хугацааны ур чадвар олгох, гэрээс болон зайнаас ажиллахыг дэмжих сургалт, 91.3 хувь нь цагаар ажиллахыг дэмжих үйлчилгээнд хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 61.1 хувь нь иргэнд санхүүгийн дэмжлэг олгох, 25.9 хувь нь богино хугацааны ур чадвар олгох, гэрээс болон зайнаас ажиллахыг дэмжих сургалт, 13.0 хувь нь цагаар ажиллахыг дэмжих үйлчилгээнд зарцуулсан байна.

Зураг 30. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2022 оны VI сарын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО

Сүүлийн 30 жилийн хугацаанд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол хамгийн бага бүртгэгдсэн нь 2021 он байсан. Харин 2022 оны I, II улирлын мэдээг харахад өмнөх оны мөн үеэс их нэмэгджээ.

2022 оны I-VI сарын байдлаар үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоор 198 хүн осолдсон бөгөөд эхний улиралд 62 (31.3 хувь) хүн, II улиралд 136 (хувь) хүн нь осолджээ. 2022 оны II улиралд осолдсон иргэд өмнөх оны мөн үеэс 66 буюу 94.3 хувиар, өмнөх улирлаас 74 буюу 1.2 дахин нэмэгдсэн. Цар тахлын үеийн хөл хорио цуцлагдан бизнесийн үйл ажиллагаа идэвхижсэн нь үүнд нөлөөлсөн байх талтай.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоор осолдсон иргэдийн 96 (70.6 хувь) нь **эрэгтэй,** 40 (29.4 хувь) нь **эмэгтэйчүүд** байна. Мөн осолдсон иргэдийн 47 (34.6 хувь) нь **хөнгөн гэмтэл,** 76 (55.9 хувь) нь **хүнд гэмтэл** авсан бол 13 (9.6 хувь) нь **нас барсан** байна.

Зураг 31. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоор осолдогчид, хэлбэр, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан шалтгааныг авч үзвэл, 31 (22.8 хувь) нь унах, бүдрэх, халтирах, 19 (14.0 хувь) нь эд зүйлд хавчуулагдах, 11 (8.1 хувь) нь унаж байгаа эд зүйлд цохигдох, 8 (5.9 хувь) нь гадны халдлагад өртөх, 5 (3.7 хувь) нь хөдөлгөөнт эд зүйлд цохигдох, 5 (3.7 хувь) нь халалт, түлэгдэлт, хөлдөлт, 3 (2.2 хувь) нь хүчилсэн болон хүчтэй хөдөлгөөн, үлдсэн 54 (39.7 хувь) нь бусад шалтгааны улмаас гарсан байна.

Зураг 32. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан шалтгаан, 2022 оны II улирал

Мэдээллийн эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

2022 оны II улирлын байдлаар үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоор осолдсон иргэдийг гэмтлийн төрлөөр нь авч үзвэл 58 (42.6 хувь) нь хугарал, 20 (14.7 хувь) нь өнгөц гэмтэл, ил шарх, 19 (14.0 хувь) нь тархи доргих, дотор эрхтний гэмтэл, 16 (11.8 хувь) нь мултрал, суналт, чинэрэлт, 6 (4.4 хувь) нь халуун хүйтний нөлөөлөл ба химийн үйлчлэлээр түлэгдэх, шалзрах, хөлдөх, 2 (1.5 хувь) нь хурц хордлого, халдвар, үлдсэн 15 (11.0 хувь) нь бусад төрлийн гэмтэл авсан байна.

Мөн 2022 оны II улирлын байдлаар үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоор осолдсон иргэдийг биеийн аль хэсэгт гэмтэл учирсныг ангиллаар нь авч үзвэл 28 (20.6 хувь) нь толгой, 14 (10.3 хувь) нь хүзүү, хүзүүний нугалам, 15 (11.0 хувь) нь нуруу, сээр, тэдгээрийн нугалам, 10 (7.4 хувь) нь их бие, дотор эрхтэн, 15 (11.0 хувь) нь дээд мөч, 8 (5.8 хувь) нь доод мөч, 46 (33.8 хувь) нь бүх бие эсвэл биеийн хэд хэдэн хэсэгт гэмтэл учирсан гэж бүртгэгдсэн байна.

Зураг 33. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоор осолдогчид, учирсан гэмтлийн төрлөөр, 2022 оны II улирал

Мэдээллийн эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

2022 оны II улирлын байдлаар нийт үйлдвэрлэлийн осол, хурц хордлогийн 58 хувь нь **09:00-16:59** цагт гарсан байна.

Зураг 34. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, гарсан цагаар, 2022 оны II улирал

Мэдээллийн эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

2022 оны II улирлын байдлаар үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан орчин авч үзвэл, 28 (20.6 хувь) нь **үйлдвэрлэлийн талбай,** 14 (10.3 хувь) нь **үйлдвэрлэлийн гадна орчин,** 15 (11.0 хувь) нь **барилга, барилгын талбай,** 10 (7.4 хувь) нь **уул, уурхай,** 15 (11.0 хувь) нь **албан газарт** (контор), үлдсэн 46 (33.8 хувь) нь бусад орчинд гарсан байна.

2022 оны II улирлын байдлаар бүртгэгдсэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 50.7 хувь нь уул уурхай, олборлолт (22.1 хувь), тээвэр ба агуулахын үйл ажиллагаа (16.9 хувь),

барилгын (11.8 хувь) салбарт гарсан байна. Өмнөх оны мөн үеэс уул уурхай, олборлолт, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа салбарт гарсан осол 2-4 дахин нэмэгдсэн байна.

Зураг 35. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого хамгийн их гарсан 5 салбар, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

2022 оны II улирлын байдлаар үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан хүчин зүйлийг тодруулахад 34 (25.0 хувь) нь техник технологийн асуудлаас, 3 (2.2 хувь) нь удирдлагын тогтолцооноос, 58 (42.6 хувь) нь хувь хүний анхаарал болгоомжгүйгээс, 41 (30.1 хувь) нь ажлын байрны орчноос болж, гарсан байна.

Зураг 36. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан хүчин зүйл, хувиар, 2022 оны II улирал

Мэдээллийн эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Хөдөлмөрийн насны хүн ам гэж 15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна.

Ажиллах хүч гэж тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм.

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно. Ажиллах хүчнээс гадуурх хүн амаас боломжит ажиллах хүчийг тодорхойлно. Мөн ажиллах хүч болон боломжит ажиллах хүч хоёрын нийлбэрээр өргөтгөсөн ажиллах хүч илэрхийлэгдэнэ.

Хөдөлмөрийн дутуу ашиглалт гэж хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно.

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно. Босго цаг гэдгийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 5 өдрийн 40 цагаар авч үзнэ.

Ажилгүй хүн гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм.

Боломжит ажиллах хүч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн ю**м.**

Ажиллах хүчний оролцооны түвшин: Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{АХОТ} = \frac{\text{Ажиллах хүч}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин: Ажиллагчдын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{ХЭТ} = \frac{\text{Ажиллагчдын тоо}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

Даатгуулагч гэж хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Нийгмийн даатгалын шимтгэл гэж нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор иргэн болон төр, ажил олгогчоос нийгмийн даатгалын санд хуульд заасан хувь хэмжээгээр урьдчилан төлөх төлбөрийг хэлнэ.

Ажилгүйдлийн тэтгэмж гэж ажилгүй болохоосоо өмнө ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг хуульд заасан болзол, журмын дагуу төлсөн даатгуулагч ажилгүй болсон бол түүнд нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Дундаж цалин гэж тайлант хугацаанд цалин, хөлс авсан ажиллагчдын тоогоор жигнэсэн нийт цалин хөлс болон тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тооны харьцаа юм.

Нэрлэсэн цалин гэдэг нь тодорхой хугацаанд хийсэн хөдөлмөрийнхөө төлөө авч буй мөнгөн төлбөрийн дүн юм.

Ажил хайгч иргэн гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.

Бүртгэлтэй ажилгүй иргэн гэж хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Байнгын ажлын байр гэж ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх ажил үүргийг;

Байнгын ажилтан нь байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн тухай болон төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг;

Албан бус ажил олгогч гэж тогтмол хугацаанд нэг буюу түүнээс дээш хүнийг цалин хөлстэй ажиллагчаар ажиллуулдаг хувираа хөдөлмөр эрхлэгч. Цаашид энэ ангиллын албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ажил олгогч гэж нэрийднэ.

Ажиллагч албан бус хөдөлмөр эрхлэгч гэж хөдөлмөрийн харилцаа нь хууль эрх зүйн хүрээнд бүрэн зохицуулагдаагүй нөхцөлд ажиллаж буй цалин хөлстэй ажиллагч. Цаашид ажилтан энэ ангиллын албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ажилтан гэж нэрийднэ.

Үйлдвэрлэлийн осол гэж хөдөлмөр эрхлэгч иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөхийг ойлгоно.

Хурц хордлого гэж цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг ойлгоно.

Осолдогчид үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн ажилтан, иргэнийг хэлнэ. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдлыг осолдогч бүрээр хамруулна.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол гэж үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн нэг ажилтан, иргэнийг нэг тохиолдол гэж үзнэ. Хэрвээ нэг осол, хордлогод нэгээс дээш тооны хүн өртсөн бол осолдогч тус бүрээр үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол гэж тооцно.

Бүлэг осол, хурц хордлого гэж нэг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод 2 буюу түүнээс дээш тооны ажилтан, иргэн өртөхийг ойлгоно. Осол, хурц хордлогод өртсөн осолдогч бүрээр үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хууль, 1995 он
2. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хууль, 2011 он
3. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай 2022-2023 оны хөтөлбөр”, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоол, 2022 он
4. Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, Үндэсний статистикийн хороо, 2019 он
5. Ажиллах хүчний судалгааны тайлан, Үндэсний статистикийн хороо, 2021 оны IV улирал

   Нийгмийн даатгалын хамрагдалт, тэтгэвэр, тэтгэмж авагчдын сарын мэдээ, Нийгмийн даатгалын ерөнхий газар
6. Ажил хайгч иргэний хөдөлгөөний сарын мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
7. Бүртгэлтэй ажилгүй иргэний хөдөлгөөний сарын мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
8. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэдийн мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
9. Хөдөлмөрийн зах зээлийн тойм 2022 оны I улирал
10. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын мэдэд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

АШИГЛАСАН ЦАХИМ ХУУДАС

1. www.legalinfo.mn
2. www.nso.mn
3. www.1212.mn
4. www.mlsp.gov.mn/sp-dictionary
5. www.ndaatgal.mn/v1/
6. www.hudulmur-halamj.gov.mn

ТЭМДЭГЛЭЛ